



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 1а/57

Номгон

Ингэний сүүний үйлдвэрийн барилга,
тоног төхөөрөмжийг хувьчлах уралдаант
сонгон шалгаруулалтын журам батлах,
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.1, 78 дугаар зүйлийн 78.1, 78.2, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 289 дүгээр “Баянхонгор аймгийн орон нутгийн өмчөөс 2025 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцөх тухай” тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын хуралдааны 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 5/07 дугаар “Эд хөрөнгө хувьчлах саналыг дэмжих тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ингэний сүүний үйлдвэрийг уралдаант сонгон шалгаруулалтаар шалгаруулах, ирүүлсэн төслийг үнэлэх, үйл ажиллагааны цаашдын үр дүнг харгалзан хувьчлах гэрээний төсөл боловсруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

Г.Энхбаяр

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

У.Балжинням

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Б.Биндэръяа

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Ичинхорлоо

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Азжаргал

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

626010155

Д.Отгонтөгс	Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн
С.Сайнхүү	Хүнс хөдөө аж ахуйн газрын Хүнс хоол үйлдвэрлэл үйлчилгээ худалдааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Б.Мөнх-Эрдэнэ	Хүнс хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга: Т.Мөнхзул	Орон нутгийн өмчийн газрын Удирдлага хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Ингэний сүүний үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийг хувьчлах уралдаант сонгон шалгаруулалтын журмыг нэгдүгээр, сонгон шалгаруулалтад тавигдах ерөнхий нөхцөл шаардлагыг хоёрдугаар, сонгон шалгаруулалтад ирүүлэх бичиг баримтыг гуравдугаар, нууцыг хадгалах гэрээг дөрөвдүгээр, үнэлгээний комиссын ажиллах удирдамжийг тавдугаар, үнэлгээний зааврыг зургаадугаар, тендерийн саналын иж бүрдлийг шалгах хуудсыг долоодугаар, үнэлгээний хуудсыг наймдугаар, үнэлгээний комиссын тусгай саналыг есдүгээр, онооны нэгдсэн хуудсыг аравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тус барилга, тоног төхөөрөмжийг хувьчлах уралдаант сонгон шалгаруулалтын үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж, тайланг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад танилцуулахыг комиссын дарга (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

5.Тус захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/430 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

Аймгийн Засаг даргын 2086 оны 02 дугаар сарын
02-ны өдрийн 4/7 дугаар захирамжийн
04 дүгээр хавсралт



НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Ингэний сүүний үйлдвэрийг хувьчлах уралдаант сонгон шалгаруулалтад ирүүлсэн тендерийн саналыг (цаашид тендер гэх) үнэлэх явцад хүлээн авах мэдээллийн нууцыг хадгалахтай холбогдуулан энэхүү гэрээг нэг талаас Орон нутгийн өмчийн газар, нөгөө талаас үнэлгээний комисс нар дараах зүйлийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг.Гэрээний зорилго

1.1.Энэхүү гэрээний зорилго нь Ингэний сүүний үйлдвэрийг хувьчлах уралдаант сонгон шалгаруулалтын тендерт оролцогчдоос ирүүлсэн тендерийн саналд үнэлгээ хийх явцад хүлээн авах аливаа мэдээллийн нууцыг хадгалахад оршино.

Хоёр.Нууц хадгалах

2.1.“Нууц мэдээлэл” гэж Тендерийн саналыг үнэлэх явцад Орон нутгийн өмчийн газраас болон бусад эх үүсвэрээр үнэлгээний комисс бичгээр буюу амаар гаргаж өгөх, Тендерт оролцогчдоос ирүүлсэн тендерийн саналтай шууд буюу шууд бусаар холбоотой албан ёсны болон худалдааны нууц бүхий аливаа мэдээллийг хэлнэ.

Гурав. Нууц хадгалах тухай

3.1.Үнэлгээний комисс нь тендерийн саналыг үнэлэх явцад хүлээн авсан нууц мэдээллийг зөвхөн энэхүү гэрээнд заасан хязгаарлалтын дагуу ашиглана.

3.2.Үнэлгээний комисс нь аливаа нууц мэдээллийг гуравдагч этгээдэд ямарваа нэгэн байдлаар (шууд буюу шууд бус) тараахгүй бөгөөд нууцыг чандлан хадгална.

3.3.Үнэлгээний комисс нь энэхүү гэрээний нөхцөл болзлыг сахин мөрдөх үүргийг өөрөө хүлээнэ.

Дөрөв.Мэдээллийг ашиглах

4.1.Үнэлгээний комисс нь тендерийн саналыг үнэлэхээс өөр бусад зорилгоор нууц мэдээллийг ашиглахгүй.

4.2.Хэрвээ шаардлагатай бол үнэлгээний комисс нь зөвхөн зөвлөгөө авах зорилгоор өөрийн мэргэжлийн зөвлөхөд нууц мэдээллийг ашиглуулна.

Тав.Бусад зүйл

5.1.Энэ гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөн үнэлгээний комисс нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.2.Үнэлгээний комисс нь энэхүү гэрээг зөрчсөний улмаас Орон нутгийн өмчийн газарт учрах аливаа хохирлын зардлыг бүрэн хариуцна.

5.3.Энэхүү гэрээтэй холбоотойгоор үүсэх аливаа маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ

.....

.....

(Албан тушаал, гарын үсэг)

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:
ҮНЭЛГЭЭНИЙ КОМИССЫГ ТӨЛӨӨЛЖ

.....

.....

.....

(Албан тушаал, гарын үсэг)

..... оныдугаар сарын-ны өдөр

Аймгийн Засаг даргын 2026 оны 02 дугаар
сарын 02-ны өдрийн 0/37 дугаар
захирамжийн 05 дугаар хавсралт



УДИРДАМЖ

“Ингэний сүүний үйлдвэрийг хувьчлах сонгон шалгаруулалтын тендерийн саналд үнэлгээ хийх тухай”

Энэхүү удирдамжийн зорилго нь:

Сонгон шалгаруулалтын тендерт оролцогчдоос ирүүлсэн тендерийн саналыг хүлээн авах, тендерийн саналыг үнэлэх, үнэлгээний маягтыг хэрхэн ашиглах болон үнэлгээ хийхэд юуг анхаарах талаар үнэлгээний комиссын гишүүдэд арга зүйн тусламж олгоход оршино. Уг удирдамж нь тендерийн журмыг орлохгүй.

1.Тендерийн саналыг хүлээн авах

Сонгон шалгаруулалтын журмын 12.3-т заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь сонгон шалгаруулалтын тендерийн саналыг хүлээн авч актын хамт үнэлгээний комисст хүлээлгэн өгнө.

Үнэлгээний комисс нь сонгон шалгаруулалтын тендерийн саналыг дугтуйг задалж эхний байдлаар хянахдаа иж бүрдлийг шалгах хуудас (маягт№1)-ыг ашиглана. Тендерт оролцогчдоос нэмэлт мэдээлэл авах болон мэдээлэл тодруулах шаардлагатай тохиолдолд асуудлыг шуурхай шийдвэрлэх үүднээс үнэлгээний комисс оролцогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбоо тогтоож ажиллана.

2.Сонгон шалгаруулалтын тендерийн саналыг үнэлэх

Үнэлгээний комиссын гишүүн нь сонгон шалгаруулалтын тендерийн саналыг үнэлж оноо өгөхдөө сонгон шалгаруулалтын журам, тендерийн саналын үнэлгээний зааврыг баримтлан (маягт№2,3)-ыг ашиглана.

Сонгон шалгаруулалтын тендерийн саналыг үнэлсэн гишүүн бүрийн үнэлгээн дээр үндэслэн үнэлгээний комиссын үнэлгээний тайланг комиссын дарга бэлтгэнэ. Үнэлгээний тайланг бэлтгэхдээ энэхүү удирдамжид хавсаргасан үнэлгээний комиссын онооны нэгдсэн хуудас (маягт№4,5)-ыг ашиглана.

3.Сонгон шалгаруулалтын тендерийн үнэлгээний тайлан


Үнэлгээний комисс нь сонгон шалгаруулалтын тендерийн үнэлгээний

тайланг аймгийн Засаг даргаар батлуулан аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулна.

Аймгийн Засаг дарга сонгон шалгаруулалтын тендерийн үнэлгээний тайланг баталсан тохиолдолд тендерийн ялагчтай Орон нутгийн өмчийн газар худалдах, худалдан авах гэрээ байгуулж аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газрын дарга нар гарын үсэг зурна.

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2056 оны 02 дугаар сарын
02-ны өдрийн 0/57 дугаар захирамжийн
...08 дугаар хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Маягт №2

Үнэлгээний комиссын гишүүн-ны хувийн үнэлгээний хуудас

Баянхонгор аймгийн Ингэний сүүний үйлдвэрийг хувьчлах уралдаант сонгон
шалгаруулах тендерт оролцогч:

№	Шалгуур үзүүлэлт	Ногдуулах дээд оноо	Өгсөн оноо	Тайлбар (тодорхойлолт)
1	2	3	4	5
1	Төслийн агуулга, үр ашиг	20		
2	Материалын бүрдэл	10		
3	Туршлага	20		
4	Ажиллах хүчний чадвар	20		
5	Санхүүгийн чадвар	10		
6	Үнийн санал	20		
	Дүн	100		

Жич: Тайлбар тодорхойлолтыг тусад нь цаасан дээр бичиж хавсаргаж болно.

ҮНЭЛГЭЭНИЙ КОМИССЫН ГИШҮҮН()

..... оныдугаар сарын.....өдөр

Аймгийн Засаг даргын..... оны дугаар сарын
02...-ны өдрийн 4/37 дугаар захирамжийн
09 дүгээр хавсралт



Маягт №3

ҮНЭЛГЭЭНИЙ КОМИССЫН ТУСГАЙ САНАЛ

..... (Байгууллага, хувь хүн) тендерт оролцогчийн саналын тухай

Баянхонгор аймгийн Ингэний сүүний үйлдвэрийг хувьчлах уралдаант сонгон
шалгаруулах шалгаруулалтад оролцогчийн тендерийн саналтай холбогдуулан
тусгайлан дараах санал өгч байна

Үүнд:

ҮНЭЛГЭЭНИЙ КОМИССЫН ГИШҮҮН()

..... оныдугаар сарын.....өдөр



۱۲۲۰ هجری قمری
 ۱۸۰۵ میلادی

$\frac{2}{0} \frac{2}{0} \frac{2}{0} \frac{2}{0} \frac{2}{0}$

مجلسو مجلس
پښتنستان د لوی کورنۍ د جمعې ۱۹۹۳
مجلسو د لوی کورنۍ د جمعې ۱۹۹۳
مجلسو د لوی کورنۍ د جمعې ۱۹۹۳

[illegible][illegible]

॥ वाचं धेनुमुपासीत ॥

[illegible]

၂၃၂

मार्गः

[illegible]

செய்தியை

[illegible]

ॐ नमो भगवते वासुदेवाय ॥

ਅੰਤਰਰਾਸ਼ਟਰੀ ਪ੍ਰਮਾਣਿਕਤਾ

ՀԱՅԿԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ ՎԵՐԱԴԱՐԱՆ

67. STAVROPOLE

ਅੰਤਰਰਾਸ਼ਟਰੀ

626010013

